



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/026/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг:
boldbaatarkhu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим
хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Ц.Аззаяа
Утас: 70432545 Цахим хаяг: azzayats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХОВД АЙМГИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН
СУДЛАЛЫН ТӨВИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ХАШ-ЭРДЭНЭ ТАНАА

**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.01.29 № 31

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ховд аймгийн Зоонозын өвчин судлалын төв нь тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл 26,524.6 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварын 12,226.0 мянган төгрөгийн тус тус ер төлбөр үүссэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Ховд аймгийн Зоонозын өвчин судлалын төвд 2025 онд амьтны дуудлага 10 удаа ирж, 60 тарвага хураагдаж хураагдсан тарвагыг шинжилгээнд бүрэн хамруулсан.

8426050018

Галзуугийн эрсдэлийн 117, хачигт халдварын 48, боомын 1, тарваган тахлын хүний өвчлөлийн 3 сэжигтэй дуудлага ирж тухай бүрт нь оношийг лабораторийн шинжилгээ хийжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	(төгрөгөөр)
			Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>317,151,246.3</u>	<u>278,556,359.8</u>
33	АВЛАГА	-	211,800.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	211,800.0
35	БАРАА МАТЕРИАЛ	317,151,246.3	278,344,559.8
351	Түүхий эд материал	295,875,116.3	261,957,129.8
35130	Эм боох материал	295,875,116.3	261,957,129.8
354	Хангамжийн материал	21,276,130.0	16,387,430.0
35410	Бичиг хэргийн материал	665,000.0	-
35430	Сэлбэг хэрэгсэл	380,000.0	-
35470	Бусад хангамжийн материал	20,231,130.0	16,387,430.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>698,145,701.4</u>	<u>626,580,679.1</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	698,145,701.4	626,580,679.1
392	Биет хөрөнгө	510,236,951.3	438,921,929.0
39201	Барилга, байгууламж, орон сууц	54,780,140.0	54,780,140.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	(46,724,140.0)	(46,724,140.0)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	121,028,000.0	121,028,000.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	(85,279,000.2)	(101,845,666.9)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	641,076,763.9	662,005,913.1
39206	Хуримтлагдсан элэгдэл	(236,209,711.3)	(305,636,382.7)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,021,690.0	13,021,690.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,559,291.2)	(9,267,791.3)
39214	Бусад үндсэн хөрөнгө	61,430,000.0	61,430,000.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,327,500.0)	(9,869,833.3)
393	Биет бус хөрөнгө	187,908,750.1	187,658,750.1
39301	Програм хангамж	1,750,000.0	1,750,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(781,249.9)	(1,031,249.9)
39303	Бусад биет бус хөрөнгө	186,940,000.0	186,940,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,015,296,947.6</u>	<u>905,137,038.9</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>38,750,637.3</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	38,750,637.3
413	Өглөг	-	38,750,637.3
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	38,750,637.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,015,296,947.6</u>	<u>866,386,401.6</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,015,296,947.6	866,386,401.6
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	275,955,180.0	275,955,180.0
51101	Өмч: - төрийн	275,955,180.0	275,955,180.0
512	Хуримтлагдсан үр дүн	595,525,416.6	446,614,870.6
51210	Өмнөх үеийн үр дүн	595,525,416.6	595,525,416.6
51220	Тайлант үеийн үр дүн	-	(148,910,546.0)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	143,816,351.0	143,816,351.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,015,296,947.6</u>	<u>905,137,038.9</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,168,354,471.2	1,048,920,014.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	211,826,071.2	20,929,149.3
120	Нийтлэг татварын бус орлого	211,826,071.2	20,929,149.3
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	211,826,071.2	20,929,149.3
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	211,826,071.2	20,929,149.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	956,528,400.0	1,027,990,865.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	956,528,400.0	1,027,990,865.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	951,528,400.0	980,750,100.0
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	5,000,000.0	47,240,765.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,036,792,728.0	1,197,830,560.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,036,792,728.0	1,197,830,560.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,026,389,065.0	1,168,956,970.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	708,896,990.1	814,670,673.1
210101	Үндсэн цалин	388,149,274.5	438,803,712.6
210102	Нэмэгдэл	214,568,865.6	273,815,141.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,407,000.0	40,701,000.0
210104	Урамшуулал	76,771,850.0	61,350,819.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,242,700.0	106,243,089.5
210201	Тэтгэврийн даатгал	61,058,500.0	67,271,589.5
210202	Тэтгэмжийн даатгал	5,851,000.0	7,339,200.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,607,200.0	12,410,700.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,024,000.0	3,378,400.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,702,000.0	15,843,200.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,849,653.6	39,316,513.7
210301	Гэрэл, цахилгаан	2,046,999.6	1,907,746.1
210302	Түлш, халаалт	32,332,350.0	32,980,143.6
210303	Цэвэр, бохир ус	3,470,304.0	4,428,624.0
2104	Хангамж, бараа материалын зардал	37,903,897.0	24,013,100.0
210401	Бичиг хэрэг	7,992,200.0	3,488,062.7
210402	Тээвэр, шатахуун	17,810,000.0	15,245,200.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	320,100.0	2,173,737.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	416,000.0	539,400.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,365,597.0	2,566,700.0
2105	Нормативт зардал	46,964,174.5	70,038,983.4
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	41,890,210.2	66,208,983.4
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,073,964.3	3,830,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,581,346.4	10,089,200.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,072,343.2	563,000.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	9,411,700.0
210604	Урсгал засвар	3,509,003.2	114,500.0
2107	Томилолт, зочны зардал	14,760,800.0	11,330,000.0
210702	Дотоод албан томилолт	14,760,800.0	11,330,000.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,195,200.0	761,239.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,700.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	99,900.0	89,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,100.0	102,700.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	91,300.0	82,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	492,900.0	442,600.0
210807	Газрын төлбөр	46,100.0	41,300.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	120,200.0	3,139.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,994,303.5	92,494,171.6
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,994,303.5	92,494,171.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,403,663.0	28,873,590.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,648,100.0	18,306,000.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	18,306,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,648,100.0	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,755,563.0	10,567,590.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,755,563.0	10,567,590.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	131,561,743.2	(148,910,546.0)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	131,561,743.2	(148,910,546.0)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,955,180.0	143,816,351.0	595,525,416.6	1,015,296,947.6
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,955,180.0	143,816,351.0	595,525,416.6	1,015,296,947.6
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	275,955,180.0	143,816,351.0	595,525,416.6	1,015,296,947.6
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(148,910,546.0)	(148,910,546.0)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	275,955,180.0	143,816,351.0	446,614,870.6	866,386,401.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	956,528,400.0	1,027,990,865.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	956,528,400.0	1,027,990,865.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	956,528,400.0	1,027,990,865.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	951,528,400.0	980,750,100.0

Зоонозын өвчин судлалын төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	5,000,000.0	47,240,765.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	956,528,400.0	1,027,990,865.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	956,528,400.0	1,027,990,865.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	946,124,737.0	999,117,275.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	696,240,437.0	775,781,082.3
210101	Үндсэн цалин	342,159,849.8	369,904,482.6
210102	Нэмэгдэл	249,061,497.9	307,212,418.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,392,832.0	40,690,815.0
210104	Урамшуулал	75,626,257.3	57,973,366.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,790,100.0	106,593,843.0
210201	Тэтгэврийн даатгал	62,735,300.0	70,243,943.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,451,200.0	7,339,200.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,411,000.0	10,662,700.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,290,200.0	3,669,600.0
210205	Эрүүл мэндийн даатгал	12,902,400.0	14,678,400.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,160,000.0	39,316,513.7
210301	Гэрэл, цахилгаан	2,642,300.0	1,907,746.1
210302	Түлш, халаалт	30,997,300.0	32,978,294.6
210303	Цэвэр, бохир ус	3,520,400.0	4,430,473.0
2104	Хангамж, бараа материалын зардал	28,525,100.0	22,431,100.0
210401	Бичиг хэрэг	8,064,400.0	2,654,800.0
210402	Тээвэр, шатахуун	17,810,000.0	15,245,200.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	320,100.0	2,442,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,008,300.0	904,400.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,322,300.0	1,184,700.0
2105	Нормативт зардал	29,608,900.0	37,150,597.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,150,300.0	32,540,997.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,458,600.0	4,609,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,844,200.0	5,752,900.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,631,700.0	271,900.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	550,000.0	5,005,200.0
210604	Урсгал засвар	11,662,500.0	475,800.0
2107	Томилолт, зочны зардал	14,760,800.0	11,330,000.0
210702	Дотоод албан томилолт	14,760,800.0	11,330,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,195,200.0	761,239.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,700.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	99,900.0	89,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,100.0	102,700.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	91,300.0	82,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	492,900.0	442,600.0
210807	Газрын төлбөр	46,100.0	41,300.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	120,200.0	3,139.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,403,663.0	28,873,590.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,648,100.0	18,306,000.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	18,306,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,648,100.0	-

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,755,563.0	10,567,590.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,755,563.0	10,567,590.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	980,750,100.0	970,182,510.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	980,750,100.0	970,182,510.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	980,750,100.0	970,182,510.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	756,752,500.0	756,746,960.3
210101	Үндсэн цалин	366,529,100.0	369,904,482.6
210102	Нэмэгдэл	311,113,500.0	288,178,296.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	32,761,700.0	40,690,815.0
210104	Урамшуулал	46,348,200.0	57,973,366.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,623,200.0	103,623,200.0
210201	Тэтгэврийн даатгал	67,273,300.0	67,273,300.0
210202	Тэтгэмжийн даатгал	7,339,200.0	7,339,200.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,662,700.0	10,662,700.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,669,600.0	3,669,600.0
210205	Эрүүл мэндийн даатгал	14,678,400.0	14,678,400.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,613,500.0	39,316,513.7
210301	Гэрэл, цахилгаан	4,186,000.0	1,907,746.1
210302	Түлш, халаалт	36,909,700.0	32,978,294.6
210303	Цэвэр, бохир ус	4,517,800.0	4,430,473.0
2104	Хангамж, бараа материалын зардал	21,831,100.0	21,831,100.0
210401	Бичиг хэрэг	2,334,800.0	2,334,800.0
210402	Тээвэр, шатахуун	14,965,200.0	14,965,200.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,442,000.0	2,442,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	904,400.0	904,400.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,184,700.0	1,184,700.0
2105	Нормативт зардал	37,604,400.0	34,750,597.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,394,200.0	32,540,997.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,210,200.0	2,209,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,752,900.0	5,752,900.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	271,900.0	271,900.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,005,200.0	5,005,200.0
210604	Урсгал засвар	475,800.0	475,800.0
2107	Томилолт, зочны зардал	8,500,000.0	7,400,000.0
210702	Дотоод албан томилолт	8,500,000.0	7,400,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,072,500.0	761,239.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	206,700.0	-

210803	Даатгалын үйлчилгээ	89,500.0	89,500.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,700.0	102,700.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	82,000.0	82,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	442,600.0	442,600.0
210807	Газрын төлбөр	41,300.0	41,300.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	107,700.0	3,139.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	980,750,100.0	970,182,510.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	980,750,100.0	970,182,510.1
131001	Улсын төсвөөс санхүүжих	980,750,100.0	970,182,510.1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.0	24.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0
620002	Гүйцэтгэх ажилтан	18.0	18.0
620003	Үйлчлэх ажилтан	5.0	5.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	47,240,765.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	47,240,765.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	28,934,765.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,034,122.0
210101	Үндсэн цалин	19,034,122.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,970,643.0
2104	Хангамж, бараа материалын зардал	600,000.0
210401	Бичиг хэрэг	320,000.0
210402	Тээвэр, шатахуун	280,000.0
2105	Нормативт зардал	2,400,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,400,000.0
2107	Томилолт, зочны зардал	3,930,000.0
210702	Дотоод албан томилолт	3,930,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,306,000.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,306,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	47,240,765.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	47,240,765.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,934,765.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,306,000.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,362.4 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Залруулагдаагүй зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар 6 зөрчил¹ илэрснээс 6,202.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, 2,944.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 1,215.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1. Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Аудитаар байгууллагын төсвөөс төлсөн төлбөрийн актыг суутган тооцоогүй, удирдлага нь нягтлан бодогч, няравын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олгосон боловч тус урамшуулалтай давхардуулан даргын 2025 оны 09 дүгээр сарын 22 өдрийн Б/46 тоот тушаалаар санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 1 сарын цалингийн урамшуулал илүү олгоод буцаан суутгаагүй, авлагаар бүртгээгүй зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 2: Цалин олгохдоо албан хаагчдын томилолтоор ажилласан хугацааны хоолны хөнгөлөлтийг суутган тооцоогүй нь Төсвийн тухай хуулийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн “20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал 1 дэх заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3.2 АЛБАН ШААРДЛАГА

Илрүүлэлт: Батлагдаагүй орон тоонд ажил хавсарсаны нэмэгдэл тооцон олгосон 6,202.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.3.батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох; гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

3.3. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.3.1 Шатахуун зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын 1648хое улсын дугаартай Toyota Sai маркын авто машин 100 км-т 15 л шатахуун зарцуулахаар олгож, тооцоо бодож байгаа нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар баталсан “Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ын хавсралт 1-ын 329 дэх заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар баталсан “Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг баримталж ажиллах, илэрсэн зөрчлийг арилгаж зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.3.2 Худалдан авалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үйл ажиллагаанд хэрэглэгдэх тусгай хэрэгсэл /калибрын сум/-г албан ёсны тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжээс худалдан аваагүй, зах зээлийн үнээс өндөр

үнээр авсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын худалдан авалтад тавих дотоод хяналтыг сайжруулж, хичнээн амьтан агнаж хэдэн сум зарцуулсан тооцоо бодож баталгаажуулах

3.3.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнд 1-12 сарын 980.7 сая төгрөгийн санхүүжилтийн мөнгөн гүйлгээ, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5. "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Ховд аймгийн Зоонозын өвчин судлалын төв	Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар баталсан "Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг баримтлаагүй.	1	715.9					1	715.9		
	Үйл ажиллагаанд хэрэглэгдэх тусгай хэрэгсэлд /калибрын сум/ авахдаа албан ёсны тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжээс худалдан аваагүй, зах зээлийн үнээс өндөр үнээр авсан.	1	500.0					1	500.0		
	Нягтлан бодогч, нярав нарт балансын урамшуулал олгосон. Байгууллагын төсвөөс төлсөн төлбөрийн актыг албан хаагчаас суутган тооцоогүй.	1	2,544.5	1	2,544.5						
	Ажилтан албан хаагчдын томилолтоор ажилласан хугацааны хоолны хөнгөлөлтийг суутган тооцоогүй.	1	400.0	1	400.0						
	Батлагдаагүй орон тоонд ажил хавсарсаны нэмэгдэл тооцон олгосон.	1	6,202.3			1	6,202.3				
	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнд 1-12 сарын 980.7 сая төгрөгийн санхүүжилтийн мөнгөн гүйлгээ, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлээгүй	1							1		
Нийт дүн		6	10,362.4	2	2,944.5	1	6,202.3	3	1,215.6		

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			